



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

“Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх,
ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг
хангах хөтөлбөр”-ийг үнэлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.7 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь хэсэг, Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны А/06 дугаар тогтоолын хавсралтын 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус VI хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Багахангай дүүргийн “Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг 2025 оны 12 сарын 01-ний байдлаар хэлэлцүүлж “90” хувийн хэрэгжилттэй “Үр дүнтэй” гэж үнэлсүгэй.

2.Дүүргийн “Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг дүүргийн Засаг дарга (А.Сүхболд)-д үүрэг болгосугай.

3.Дүүргийн “Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т даалгасугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (М.Давааням)-д даалгасугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ

1225010072